

An illustration of a Mongolian warrior in traditional red and black clothing, riding a green horse. The background features a blue sky with white clouds and stylized yellow and red clouds. The text is overlaid on the lower part of the image.

Монгол ардын члэгэр

Тэнгэрийн

ХҮЛЭГ



Тэнгэрийн хүлэг

Улаанбаатар хот
2007 он

ТЭНГЭРИЙН ХҮЛЭГ

Боловсруулсан:

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:

Чимэг зургийг зурсан:

Монгол бичгээр буулгасан

Ж.Дандондог

Н.Буянжаргал

Б.Болормаа

Х.Оюунчулуун



Хэвлэл нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

Урьд Сэцэн ханы нутагт Ажив, Готов гэж ах дүү хоёр сайн эр байжээ. Тэр хоёр угаас ядуу зүдүү учир хар багаасаа бусдад зарцлагдан байснаа, нас бие гүйцэн эрийн цээнд хүрмэгц хоёул босч, уул хаданд орогнон хулгай хийж амь зуусаар нутаг хошуунаас гарч баян нүүс талж энд тэндэхийн адуу мал хөөсөөр нэрд гарчээ.

Улмаар тэд халх даяар зартай сайн эрсийн зэрэгт хүрч удалгүй бусад аймгийн хошуу тамганаас "Сэцэн ханы тамгын газарт "Хоёр хулгайчаа татан авч шийтгэж өг!" гэсэн бичиг ирэх болжээ.

Тийнхүү ах дүү хоёр алхах гишгэх газаргүй болтлоо доройтон унаа мориор хомсдож яах ч аргагүйдэн мухарджээ.



ᠮᠠᠭᠠᠨᠨᠢᠨᠠᠨᠤ ᠰᠡᠴᠡᠨᠬᠠᠨᠠ ᠨᠤᠲᠠᠭᠲᠤ ᠠᠵᠢᠪᠤ, ᠭᠣᠲᠣᠪᠤ ᠭᠡᠭᠡ ᠠᠬᠤ ᠳᠦᠭᠦ ᠬᠣᠭᠦᠷ ᠰᠠᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠷᠢᠨ ᠪᠠᠶᠢᠵᠡᠭᠡ. ᠲᠡᠷ ᠬᠣᠭᠦᠷ ᠤᠭᠠᠰᠤ ᠶᠠᠳᠤ᠎ᠠ ᠰᠦᠳᠦᠭᠦ ᠠᠴᠢᠷ ᠬᠠᠷ ᠪᠠᠭᠠᠰᠠᠭᠠ ᠪᠤᠰᠡᠳᠤᠷ ᠵᠠᠷᠴᠢᠯᠠᠭᠠᠳᠠᠨ ᠪᠠᠶᠢᠰᠨᠠᠭᠠ, ᠨᠠᠰ ᠪᠢᠶᠡ ᠭᠦᠶᠢᠴᠡᠨ ᠶ᠋ᠢᠷᠢᠨ ᠴᠡᠡᠨᠳᠤ ᠬᠦᠷᠮᠡᠭᠴᠢ ᠬᠣᠪᠤᠯ ᠪᠣᠰᠴᠤ, ᠤᠯᠤᠰ ᠬᠠᠳᠠᠨᠳᠤ ᠣᠷᠣᠭᠨᠠ ᠬᠣᠯᠭᠠᠢ ᠬᠢᠶᠢᠵᠡ ᠠᠮᠢᠶᠤ ᠵᠠᠭᠤᠰᠠᠷ ᠨᠤᠲᠠᠭ ᠬᠣᠰᠢᠭᠤᠨᠠᠭᠠᠰ ᠭᠠᠷᠴᠢ ᠪᠠᠶᠠᠨ ᠨᠥᠦᠰ ᠲᠠᠯᠵᠢ ᠡᠨᠳᠤ ᠲᠡᠨᠳᠡᠬᠢᠶᠢᠨ ᠠᠳᠤᠭᠠ ᠮᠠᠯ ᠬᠡᠭᠡᠰᠡ᠋ᠪᠡᠷ ᠨᠠᠶᠦᠷᠳᠤ ᠭᠠᠷᠴᠢᠶᠡ.

ᠤᠯᠮᠠᠭᠠᠷ ᠲᠡᠳᠤ ᠬᠠᠯᠬᠤ ᠳᠠᠶᠠᠷ ᠵᠠᠷᠲᠠᠶᠢ ᠰᠠᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠷᠢᠨ ᠵᠡᠷᠦᠭᠲᠤ ᠬᠦᠷᠴᠢ ᠠᠳᠠᠯᠭᠦᠢ ᠪᠤᠰᠠᠳᠤ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ ᠬᠣᠰᠢᠭᠠ ᠲᠠᠮᠭᠠᠨᠠᠰ "ᠰᠡᠴᠡᠨᠬᠠᠨᠠ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷᠲᠤ "ᠬᠣᠭᠦᠷ ᠬᠣᠯᠭᠠᠢᠴᠠᠭᠠ ᠲᠠᠲᠠᠨ ᠠᠪᠴᠢ ᠰᠢᠶᠢᠲᠦᠭᠡᠭᠡ ᠶ᠋ᠢᠷᠢᠭᠡ" ᠭᠡᠰᠡᠨ ᠪᠢᠴᠢᠭᠢ ᠢᠷᠦᠬᠤ ᠪᠣᠯᠵᠡᠭᠡ.

ᠲᠢᠶᠢᠨᠬᠦᠭᠦ ᠠᠬᠤ ᠳᠦᠭᠦ ᠬᠣᠭᠦᠷ ᠠᠯᠶᠠᠬᠤ ᠭᠢᠰᠬᠡᠬᠡ ᠭᠠᠰᠠᠷᠭᠦᠢ ᠪᠣᠯᠲᠤᠯᠤ ᠳᠣᠷᠣᠶᠢᠲᠣᠨ ᠤᠨᠠᠭᠠ ᠮᠣᠷᠢᠣᠷ ᠬᠣᠮᠰᠡᠳᠣᠵᠡ ᠶᠠᠬᠤ ᠴᠢ ᠠᠷᠭᠠᠭᠦᠳᠡᠨ ᠮᠤᠬᠠᠷᠳᠢᠵᠡᠭᠡ.

ᠮᠠᠭᠠᠨᠨᠢᠨᠠᠨᠤ ᠰᠡᠴᠡᠨᠬᠠᠨᠠ ᠨᠤᠲᠠᠭᠲᠤ ᠠᠵᠢᠪᠤ, ᠭᠣᠲᠣᠪᠤ ᠭᠡᠭᠡ ᠠᠬᠤ ᠳᠦᠭᠦ ᠬᠣᠭᠦᠷ ᠰᠠᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠷᠢᠨ ᠪᠠᠶᠢᠵᠡᠭᠡ. ᠲᠡᠷ ᠬᠣᠭᠦᠷ ᠤᠭᠠᠰᠤ ᠶᠠᠳᠤ᠎ᠠ ᠰᠡᠳᠦᠭᠦ ᠠᠴᠢᠷ ᠬᠠᠷ ᠪᠠᠭᠠᠰᠠᠭᠠ ᠪᠤᠰᠡᠳᠤᠷ ᠵᠠᠷᠴᠢᠯᠠᠭᠠᠳᠠᠨ ᠪᠠᠶᠢᠰᠨᠠᠭᠠ, ᠨᠠᠰ ᠪᠢᠶᠡ ᠭᠦᠶᠢᠴᠡᠨ ᠶ᠋ᠢᠷᠢᠨ ᠴᠡᠡᠨᠳᠤ ᠬᠦᠷᠮᠡᠭᠴᠢ ᠬᠣᠪᠤᠯ ᠪᠣᠰᠴᠤ, ᠤᠯᠤᠰ ᠬᠠᠳᠠᠨᠳᠤ ᠣᠷᠣᠭᠨᠠ ᠬᠣᠯᠭᠠᠢ ᠬᠢᠶᠢᠵᠡ ᠠᠮᠢᠶᠤ ᠵᠠᠭᠤᠰᠠᠷ ᠨᠤᠲᠠᠭ ᠬᠣᠰᠢᠵᠡᠨᠠᠭᠠᠰ ᠭᠠᠷᠴᠢ ᠪᠠᠶᠠᠨ ᠨᠥᠦᠰ ᠲᠠᠯᠵᠢ ᠡᠨᠳᠤ ᠲᠡᠨᠳᠡᠬᠢᠶᠢᠨ ᠠᠳᠤᠭᠠ ᠮᠠᠯ ᠬᠡᠭᠡᠰᠡ᠋ᠪᠡᠷ ᠨᠠᠶᠦᠷᠳᠤ ᠭᠠᠷᠴᠢᠶᠡ.

ᠤᠯᠮᠠᠭᠠᠷ ᠲᠡᠳᠤ ᠬᠠᠯᠬᠤ ᠳᠠᠶᠠᠷ ᠵᠠᠷᠲᠠᠶᠢ ᠰᠠᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠷᠢᠨ ᠵᠡᠷᠦᠭᠲᠤ ᠬᠦᠷᠴᠢ ᠠᠳᠠᠯᠭᠦᠢ ᠪᠤᠰᠠᠳᠤ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ ᠬᠣᠰᠢᠵᠡ ᠲᠠᠮᠭᠠᠨᠠᠰ "ᠰᠡᠴᠡᠨᠬᠠᠨᠠ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷᠲᠤ "ᠬᠣᠭᠦᠷ ᠬᠣᠯᠭᠠᠢᠴᠠᠭᠠ ᠲᠠᠲᠠᠨ ᠠᠪᠴᠢ ᠰᠢᠶᠢᠲᠦᠭᠡᠭᠡ ᠶ᠋ᠢᠷᠢᠭᠡ" ᠭᠡᠰᠡᠨ ᠪᠢᠴᠢᠭᠢ ᠢᠷᠦᠬᠤ ᠪᠣᠯᠵᠡᠭᠡ.

ᠲᠢᠶᠢᠨᠬᠦᠭᠦ ᠠᠬᠤ ᠳᠦᠭᠦ ᠬᠣᠭᠦᠷ ᠠᠯᠶᠠᠬᠤ ᠭᠢᠰᠬᠡᠬᠡ ᠭᠠᠰᠠᠷᠭᠦᠢ ᠪᠣᠯᠲᠤᠯᠤ ᠳᠣᠷᠣᠶᠢᠲᠣᠨ ᠤᠨᠠᠭᠠ ᠮᠣᠷᠢᠣᠷ ᠬᠣᠮᠰᠡᠳᠣᠵᠡ ᠶᠠᠬᠤ ᠴᠢ ᠠᠷᠭᠠᠭᠦᠳᠡᠨ ᠮᠤᠬᠠᠷᠳᠢᠵᠡᠭᠡ.











Аг шарилж өвсөө норгон биедээ нааж, бугуйлаа зэхээд далд хэвтжээ. Нэг шөнө өнгөрч гэнэ. Хулан, тахь алга гэнэ. Маргааш нь өнгөрч. Байдаггүй. Дараах шөнө нь ч бас нүд цавчсангүй гэнэ. Бас л байдаггүй. Готов нь Аживаасаа эмээх тул хэдий ядарч туйлдавч чимээгүй л суужээ. Дараах өдөр өнгөрч, шөнө болоход Готов нь "Юу ч ирдэггүй ус юм байлгүй" хэмээн сэтгэлээр унан уйлж суусан гэнэ. Хоёр шөнө нойргүй болоод ч тэр үү, нүд нь анилдан дэн дун байжээ. Гэтэл гэнэт Аживын исгэрэх сонсогдмогч Готов ч ухаан орон өндийж, усны зүгээс олон адуу бололтой амьтан ч хамар хоолой нь тачигнан, хурдан хөл нь шижигнэсээр дэргэдэх жимээр нь хуй салхи мэт өнгөрөхөд арай гэж бугуйлаа шидсэн боловч юу ч үл тээглэв гэнэ. Гэтэл Ажив нь нэгэн адууг бугуйлдчихсан чирэгдэн зүүгдэн, цаад адуу нь чарлан цамнаж, сүйд болж байгаа үзэгдэх бөгөөд сая ухааран харвал үүр тэмдэгэн гийж байна гэнэ.

- Бушуухан оосролоод ав! гэж Ажив нь хашгиран их элсэн дундуур улан чирэгдэж.

.. Өнгөрч, шөнө гэнэ. Хулан, тахь алга гэнэ. Маргааш нь өнгөрч. Байдаггүй. Дараах шөнө нь ч бас нүд цавчсангүй гэнэ. Бас л байдаггүй. Готов нь Аживаасаа эмээх тул хэдий ядарч туйлдавч чимээгүй л суужээ. Дараах өдөр өнгөрч, шөнө болоход Готов нь "Юу ч ирдэггүй ус юм байлгүй" хэмээн сэтгэлээр унан уйлж суусан гэнэ. Хоёр шөнө нойргүй болоод ч тэр үү, нүд нь анилдан дэн дун байжээ. Гэтэл гэнэт Аживын исгэрэх сонсогдмогч Готов ч ухаан орон өндийж, усны зүгээс олон адуу бололтой амьтан ч хамар хоолой нь тачигнан, хурдан хөл нь шижигнэсээр дэргэдэх жимээр нь хуй салхи мэт өнгөрөхөд арай гэж бугуйлаа шидсэн боловч юу ч үл тээглэв гэнэ. Гэтэл Ажив нь нэгэн адууг бугуйлдчихсан чирэгдэн зүүгдэн, цаад адуу нь чарлан цамнаж, сүйд болж байгаа үзэгдэх бөгөөд сая ухааран харвал үүр тэмдэгэн гийж байна гэнэ.

- Бушуухан оосролоод ав! гэж Ажив нь хашгиран их элсэн дундуур улан чирэгдэж.





Тэр адуу сэнс мэт эргэлдэн цамнах нь аймшигтай харагдав гэнэ. Готов нь ойртож эс чадан сандарч, хоёул нэлээд бүдилжээ. Гэвч хүмүүс тулдаа нөгөө адгуусыг дийлж, эцэст нь эмээл тохон мордсон гэдэг. Сул элсэн дунд ямар ч эмнэг хангал морь тэр бүр булгиж базаадаггүй шиг тахь хэчнээн цамнавч төдийлөн догширч шальсангүй, Аживын унаа болжээ. Тэр нь залуу тахь байсан бөгөөд Ажив хүч чадлаар ааглан номхруулж аваад "Дахин нэгийг барьж авъя" гэсэнд түрүүчийн явдалд амь наана, там цаана гарсан Готов "Үүгээрээ л зогсьё" гээд залбирчээ. Чингээд "тэнгэрийн унаа" хэмээх тахь барьж унасан Ажив нь урьдын явдлаа үргэлжлүүлэн амь зууж, Готов нь эзэн ноёдоо гэмээ хүлээн очсон аж. Гэтэл түүнийг хар гэр, банз, шаахай угтаж. Дээр нь Аживыг барьж өг! гэж өдөр шөнөгүй тулган шахах хүнд зовлонд унагажээ. Тэр жил Сэцэн хан аймагт наадам болж арав гаруй жил нутагтаа ирээгүй Ажив түүнд иржээ.



Үүгээрээ л зогсьё ..
 Чингээд "тэнгэрийн унаа" хэмээх тахь барьж унасан Ажив нь урьдын явдлаа үргэлжлүүлэн амь зууж, Готов нь эзэн ноёдоо гэмээ хүлээн очсон аж. Гэтэл түүнийг хар гэр, банз, шаахай угтаж. Дээр нь Аживыг барьж өг! гэж өдөр шөнөгүй тулган шахах хүнд зовлонд унагажээ. Тэр жил Сэцэн хан аймагт наадам болж арав гаруй жил нутагтаа ирээгүй Ажив түүнд иржээ.





ЧИХЭР ХҮЛХВЭЛ АРААНД УУСНА НОМ УНШВАЛ ТОЛГОЙД ҮЛДЭНЭ

Хүүхдийн шилдэг үлгэрийн номын эхний хуудсан дээр золгож буй гүн хүндлэлт эцэг эхчүүд ээ!

Хэрэв та үр хүүхдэдээ сайн ном авч өгвөл тэднийг хүмүүжүүлэх их ажлынхаа дийлэнх хувийг хийлээ гэж найдаж болно. Үлгэрийн баатрууд тэдэнд туслаж мэргэн оюун, уран сэтгэмж, сайхан сэтгэлийг бэлэглэнэ.

Таны хүүхдүүд энэ номоор дамжин үсэг нүдэлж үг холбосоор үлгэрийн гайхамшигт ертөнц рүү орж байна. Чихэрт дургүй хүүхэд гэж байдаггүй. Чихэр гагцхүү амтлах эрхтэнд нөлөөлдөг бол ном таван мэдрэхүйг эзэмдэнэ. Тиймээс номын амт нь чихрийнхээс хавьгүй илүү болохыг хүүхдүүд аяндаа мэдэрнэ. Энэхүү номын зургийг уран сайхны өндөр түвшинд урласан миний шавь Б.Болормаа 2005 онд Олон улсын НОМА уралдааны Гран при шагнал хүртэж Монголын хүүхдийн номын зураачдын нэрийг дэлхийн сонорт хүргэсэн билээ. Ийнхүү шилдэг үлгэр, сайхан зураг найрсан нийлсэн номын амтат чихрийг үр хүүхдийн тань гарт атгуулья. Таалан соёрхон оюу?

Олон улсын хүүхдийн утга зохиолын дөрвөн удаагийн шагналт, зохиолч Жамбын Дашдондог



Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.